

Батлав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ОРЛОГЧ / С. БҮРЭНБАТ

ОРОН НУТАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРУУДАЙ  
ХАМТРАН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

УХА0122

Аудитын нэр: Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн  
төлөлтийн байдал  
Код: УАГ-ГАГ/2017/12-ГА-01

#### Үндсэн мэдээлэл

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 11/9920 дугаар албан бичиг, Төсвийн байнгын хорооны 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 9/10647 дугаар албан бичиг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн ХЭГ/1880 дугаар албан бичиг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/219 дүгээр тушаалыг үндэслэн Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн төлөлтийн байдалд гүйцэтгэлийн аудит хийсэн болно.

Аудитын тайлагналын үе шатанд Монгол Улсын Ерөнхий аудиторын өгсөн чиглэлийн дагуу аудитын хамрах хүрээ, багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, шинэчилсэн нэмэлт горим хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2018 оны 10 дугаар сарын 17-ны батлуулж, аудитыг 2018 оны 10 дугаар сарын 24-нд эхлүүлж, талбарын ажлыг гүйцэтгэж байна.

Өмнөх аудитад хамрагдсан зээлийн түүврийн хэмжээ хэт бага байснаас төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд бодит үнэлгээ өгөхөд хангалтгүй гэж үзсэн бөгөөд нэмэлт аудитаар түүврийн хэмжээг нэмэгдүүлж, зээлийн ашиглалтыг илүү өргөн хүрээтэй хянаж, хөтөлбөрийн үр дүнд чиглүүлэх шаардлага үүссэн.

#### Хийх ажлууд:

Аудитын хамрах хүрээ өргөжиж улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн 385 төсөл, 9 хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкуудаар дамжуулан 1617 зээлдэгчид олгосон зээлийн ашиглалт, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт хийхэд орон нутаг дахь аудитын байгууллагын дэмжлэг зайлшгүй шаардлагатай байна. Төслүүдийг төрлөөр нь ангилбал,

1. 888 төслийн хүрээнд 702,
2. Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах богино хугацааны хөтөлбөрийн хүрээнд 93,
3. ЖДҮ 70 хөтөлбөрийн хүрээнд 406,
4. ЖДҮ-50 хөтөлбөрийн хүрээнд 151,
5. Мах хөтөлбөрийн хүрээнд 10,
6. Арьс ширний үйлдвэрлэлийн төслүүдэд 58,
7. Ноолуурын үйлдвэрлэлд 11,
8. Голомт банкаар дамжуулан олгосон зээлийн хөтөлбөрийн хүрээнд 168,
9. Мах хөтөлбөрийн хүрээнд 10,
10. Экспортыг дэмжих, импортыг орлох хөтөлбөрийн хүрээнд 18 төсөл хэрэгжиж байна.

Дээрх зээлээс 21 аймагт байршилтай 891 төсөл, хөтөлбөрт 279.6 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байна.

Иймд орон нутагт байршилтай дээрх төслүүдэд олгосон зээлийн хэрэгжилтэд аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн дагуу аудиторуд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Зээл олгогдсон төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлсон эсэх
2. Зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх
3. Төсөл хэрэгжиж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх

Аудитын багаас орон нутгийн аудиторуудыг дараах мэдээллээр хангана. Үүнд:

- Хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг албан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлэх /Ж.Мөнхбилгүүн 2018 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн дотор/
- Мэдээллийн нэгтгэн ирүүлэх маягт, хүснэгт /И.Туяадарь 2018 оны 11 дүгээр сарын 7-ны дотор хариуцсан ажилтан хүргүүлнэ/


**Тайлагналын хугацаа:**

- Зээлийн олголтын үр дүнд хяналт хийх асуудалтай холбоотой мэдээллийг орон нутагтай харьцах  
Аудитор И.Туяадарь [tuyadarii@audit.gov.mn](mailto:tuyadarii@audit.gov.mn); 9907-2602  
Аудитор Б.Мөнхтуяа [munkhtuyab@audit.gov.mn](mailto:munkhtuyab@audit.gov.mn); 9111-2340 нартай холбогдож авна.
- Зээлийн зарцуулалт, үр дүнтэй холбоотой мэдээллийг нэгдсэн маягтын дагуу бэлтгэж Үндэсний аудитын газарт 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ.

Хавсралтаар орон нутагт байршилтай төсөл, хөтөлбөрт олгосон зээлийн нэгтгэлийг харуулав.

Хянасан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Л.ОДГЭРЭЛ

Боловсруулсан:

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Б.САРУУЛ